



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 11 сарын 11 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө эхэлсэн боловч дуусгаагүй хяналт шалгалтыг тухайн салбарын хяналтыг хэрэгжүүлэхээр чиг үүрэг шилжүүлэн авсан байгууллага, холбогдох улсын байцаагч гүйцэтгэнэ.

2 дугаар зүйл. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хийсэн хяналт шалгалттай холбоотой асуудлаар хуульд заасан журмаар гаргасан гомдлыг тухайн салбарын хяналтыг хэрэгжүүлэхээр чиг үүрэг шилжүүлэн авсан байгууллага шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл. 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан журмын дагуу батална.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР